

Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийн талаарх олон нийтийн хэлэлцүүлгийн санал, дүгнэлт

Эдийн засаг, хөгжлийн яам Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах хүрээнд Төсвийн тухай хуулийн 28¹.4 дэх заалт, Засгийн газрын 2024 оны “Журам батлах тухай” 93-р тогтоолыг тус тус үндэслэн олон нийтийн хэлэлцүүлгийг 2024 оны 3 дугаар сарын 29-ны өдөр зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт иргэд, иргэний нийгмийн байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага, төрийн захиргааны төв байгууллага, холбогдох салбарын төсвийн ерөнхийлөн захирагч, төрийн захиргааны болон бусад байгууллагын санхүү, төсвийн асуудал хариуцсан нийт 200-аад гаруй хүн оролцсон. Оролцогчдын саналыг цаасан болон цахим авсан болно.

Олон нийтийн хэлэлцүүлгийн үеэр гарсан саналууд

Олон нийтийн хэлэлцүүлэгт оролцогчид төсвийн алдагдлын ДНБ-тэй харьцуулсан харьцааг сайжруулах, халамжийн бодлого, төлөвлөлтийг сайжруулан, хөдөлмөр эрхлэлттэй уялдуулах, хөгжлийн бодлого болон төсвийн төлөвлөлтийн уялдааг хэрхэн хангах, төсвийн зардлыг үе шаттайгаар бууруулах, эдийн засгийн төрөлжүүлэх замаар төсвийн орлого бүрдэлтийг сайжруулах зэрэг санал ирүүлсэн байна. Цалин, тэтгэвэр, тэтгэмжийн өсөлт нь инфляц, цаашлаад төсөвт хэрхэн нөлөөлөх, мөнгөний болон сангийн бодлогын уялдааг хэрхэн хангах талаар судлах шаардлагатай хэмээн холбогдох байгууллагууд санал гаргасан байна. Мөн төсвийн төсөөлөл, тооцоололдоо зуд, уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийг тусгах талаар санал дэвшүүлсэн байна.

Эдийн засгийн төсөөллийн санал асуулга

Хэлэлцүүлгийн явцад оролцогчдоос эдийн засгийн төсөөллийн талаарх санал асуулгыг цахим асуулгын систем ашиглан зохион байгуулсан бөгөөд нийт оролцогчдоос 76 хүн оролцсон байна. Уг санал асуулга нь 2024-2027 оны эдийн засгийн өсөлт, үнийн өсөлтийн төсөөлөл болон төсвийн алдагдлын талаарх асуултуудаас бүрдсэн.

Асуулгын үр дүнгээс харахад хэлэлцүүлэгт оролцогчид эдийн засгийн өсөлтийг 2027 онд хүртэл 6-аас дээш хувьд хадгалагдана хэмээн үзсэн бол инфляцын түвшин 2024, 2025 онд 6-7 хувь, 2026-2027 онуудад 5 хувь болж буурна гэсэн хүлээлттэй байна. Нийт оролцогчдын 63.5 хувь нь төсвийн алдагдлыг бууруулан, алдагдалгүй болон ашигтай байлгах нь зүйтэй хэмээн үзжээ.

Цахим хэлбэрээр ирүүлсэн саналууд

Дунд хугацааны төсвийн бодлогын баримт бичгийг боловсруулахад олон талын оролцоог хангах хүрээнд олон нийтэд нээлттэй санал асуулгыг цахимаар явуулсан. Тус санал асуулгад иргэний нийгмийн байгууллага, иргэн, эрдэм шинжилгээний байгууллага, төрийн байгууллага, хувийн хэвшлийн төлөөлөл саналаа илгээсэн бөгөөд иргэдийн санал дийлэнх хувийг эзэлж байна.

Тус санал асуулгад ирэх жилүүдийн эдийн засгийн өсөлтийн талаар харьцангуй эерэг төсөөлөлтэй байгаа бол богино хугацаанд инфляц төв банкны зорилтот түвшнээс өндөр байна гэсэн хариуг илгээжээ. “Таны хувьд төсвийн төлөвлөлтийн ямар үзүүлэлтэд хамгийн их анхаарал хандуулах шаардлагатай гэж үзэж байна вэ?” гэсэн асуултад төсвийн үр ашигтай хуваарилалтыг сайжруулах гэсэн саналыг хамгийн өндөр буюу санал асуулгад оролцогсдын 75 хувь нь сонгосон байна. Төсвийн зардлыг бууруулах, төсвийн үр дүнд анхаарах гэсэн хариултаудыг харгалзан 50 хувь, 42 хувь нь илгээсэн байна.

Түүнчлэн санал асуулга дээрх нээлттэй бичих хэсэгт хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэж, санхүүжилтийг хуваарилах, орлогыг нийгэм ард иргэдэд өгөөжтэй арга хэмжээнд зарцуулах, төсвийн алдагдлыг бууруулах, хувийн хэвшлийг дэмжсэн арга хэмжээ хэрэгжүүлэх, эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулах, Засгийн газраас бараа, бүтээгдэхүүний үнийн зохицуулалт хийхгүй байх, үр дүнд анхаарах зэрэг саналуудыг харьцангуй олон давтамжтай бичиж ирүүлсэн байна.

Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөлд ирүүлсэн саналын тусгагдсан байдал

№	Санал ирүүлсэн байгууллага	Ирүүлсэн санал	Тайлбар
1	Үндэсний аудитын газар	1. Салбар болон хөгжлийн бодлогыг төсвийн хүрээнд тусгадаг болох 2. Иргэд болон тодорхой үйл ажиллагаанд чиглэсэн ямар төсвийн бодлогыг баримталж байгаагаа тусгадаг байх 3. Мөнгөний бодлого, сангийн бодлого хоорондын уялдаа хангагдах үзүүлэлтийг судлах	Эдийн засгийн үзүүлэлтүүдийн төсөөлөл хийж, зорилтыг тодорхойлохдоо эдгээр бодлогуудыг харгалзан үзсэн.
2	Үндэсний статистикийн хороо	1. Цалин, тэтгэврийн нэмэгдлийн инфляцад нөлөөлөх нөлөөллийг авч үзэх 2. Зудын эрсдэлийг тооцох	Цалин, тэтгэврийн өсөлт болон зудын эрсдэлийг тооцсон.
3	Улсын Их Хурлын тамгын газар	1. Халамжийн зардлыг бууруулах, халамжийн бодлого, төлөвлөлтийг сайжруулан төсөвт тусгах 2. Хөдөлмөр эрхлэлтэд чиглэсэн төсвийн бодлого баримтлах	УХЖТ-нд тусгасан.
4	Сангийн яам	Төсвийн тодотгол хийхээс сэргийлэхийн тулд халамжийн зардал болон хөрөнгийн зардлыг тодорхой хэмжээнд хөдөлж болох заалтыг ТТБТХ-д тусгах	Саналыг хүлээн авсан.
5	Зам, тээврийн хөгжлийн яам	Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний дараа онуудад санхүүжих дүнг бүрэн тусгадаг байх	Саналыг хүлээн авсан.
6	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	Экспортын төсөөлөл нь холбогдох салбарын төсөөллөөс хэт өндөр байгааг анхаарах	Экспортлогч ААН-үүдтэй зөвлөлдөн төсөөлөл боловсруулсан.

7	Төрийн байгууллага	1. Зээлийн хүү, ханшийн төсөөлөл, нэг хүнд ногдох үндэсний нийт орлогын төсөөллийг цуг зарлах 2. Зэсийн үнийн төсөөллийг эргэж харах	Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан үзүүлэлтийг тусгана.
8	Төрийн байгууллага	1. Татварын оновчтой бодлого баримтлах хэрэгтэй байна.	Саналыг хүлээн авсан.
9	Төрийн байгууллага	1. Өрийн дээд хязгаарыг 40% болгох нь зүйтэй 2. Эрэлтийн инфляцыг бууруулахад баримталж буй бодлогыг танилцуулгад тусгах	Саналыг хүлээн авсан.
10	Төрийн байгууллага	Дунд хугацааны төсвийн тодотгол хийх боломжгүй болж байгаа тул аргачлалыг улам бүр сайжруулах	Саналыг хүлээн авсан.
11	Дэлхийн банк	1. Уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийг бууруулахад баримтлах бодлогыг тусгах 2. Тодотгол хийх боломж хязгаарлагдаж байгаа тул сайн муу 2 хувилбараар ТХМ-г танилцуулдаг байх	1. УХЖТ-нд тусгасан. 2. Төсвийн тухай хуулийн хүрээнд ТХМ-ийг 1 хувилбараар боловсруулдаг.
12	Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн	1. Зарлага/ДНБ харьцааг бууруулах 2. Инфляц хэт өөдрөг 3. төсвийн тооцоо хэт өөдрөг	Саналыг хүлээн авсан.
13	СЭЗИС	1. Боловсруулах салбарт гадаадын хөрөнгө оруулалт татах	Саналыг хүлээн авсан.

14	Мандах Их Сургууль	1. Эдийн засгийг төрөлжүүлэх замаар төсвийн орлого бүрдүүлэлтийг сайжруулах шаардлагатай байна. 2. Тэтгэвэр, цалингийн нэмэгдэл инфляцад хэрхэн нөлөөлөх нөлөөллийг судлах	Саналыг хүлээн авсан.
15	Хувийн хэвшил	Хувийн хэвшлийг түлхүү дэмжсэн төсвийн бодлого баримталж, хөрөнгө оруулалтын орон зай гаргах	УХЖТ-нд тусгасан.
16	Олон улсын байгууллага	Хөрөнгийн зардлын дээд хязгаарыг тооцоход УХОХ-ийн зардлыг илүү үндэслэлтэйгээр тооцож тусгадаг байх. Дунд хугацааны бодлогын баримт бичиг туссан хөгжлийн зорилго, зорилтыг хангахад дунд хугацааны төсвийн төлөвлөлтийг илүү бодит тооцооллоор уялдуулдаг байх.	Саналыг хүлээн авсан.
17	Төрийн байгууллага	Хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэж, санхүүжилтийг хуваарилах	Саналыг хүлээн авсан.
18	Иргэний нийгмийн байгууллага	Төсвийн алдагдлыг бууруулах шаардлагатай. Төсвийн сахилга батыг нэмэгдүүлж, тодотгол хийхгүй байх. Төсвийн өндөр зардал нь инфляцын суурь болж, цаашлаад ханшийн дарамтыг нэмэгдүүлж болзошгүйг анхаарах, энэ талаарх нөлөөллыг тооцож иргэдэд танилцуулах.	Саналыг хүлээн авсан.
19	Иргэний нийгмийн байгууллага	Эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулах	Саналыг хүлээн авсан.
20	Иргэний нийгмийн байгууллага	ЗГ-аас бараа, бүтэгдэхүүний үнийн зохицуулалт хийхгүй байх	Саналыг хүлээн авсан.

21	Иргэний нийгмийн байгууллага	Зээлийн хүүг бууруулахын тулд инфляцыг бууруулахад чиглэсэн бодлогыг илүү хэрэгжүүлэх нь зүйтэй.	Саналыг хүлээн авсан.
22	Иргэний нийгмийн байгууллага	2025 оны улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд туссан ажил цаашлаад 2025 оны нийгэм эдийн засгийн нөхцөл байдал зэрэг гадаад дотоод нөхцөл байдлыг тооцон үзэх хэрэгтэй.	Саналыг хүлээн авсан.
23	Иргэн	Салбар дундын хэрэгжилтийг хангах	УХЖТ-нд тусгасан.
24	Иргэн	Хэлэлцүүлгийн хугацааг сунгах, хариулт оновчтой байх	Саналыг хүлээн авсан.
25	Иргэн	Гадаадын банк оруулж ирэх тал дээр нарийн судалгаа хийх шаардлагатай	Саналыг хүлээн авсан.
26	Иргэн	Төсвийн орлого, зарлагыг бодитоор тооцох	Саналыг хүлээн авсан.
27	Иргэн	Дунд хугацааны төсвийн тодотгол хийх боломжгүй болж байгаа тул аргачлалыг улам бүр сайжруулах	Саналыг хүлээн авсан.
28	Иргэн	Цалин, тэтгэвэр нэмэх	Инфляцтай уялдуулах нэмэхээр тооцоолсон.
29	Иргэн	Орлогыг үр ашигтай, нийгэм ард иргэдэд хэрэгтэй арга хэмжээнд зарцуулах хэрэгтэй байна	Саналыг хүлээн авсан.


Хавсралт 1. Эдийн засгийн төсөөллийн санал асуулгын дүн

1. Та 2024 онд үнийн өсөлтийн түвшинг хэдэн хувь байна гэж таамаглаж байна вэ?

[More Details](#)

[Insights](#)

3%-аас бага	0
4%	1
5%	3
6%	24
7%	23
8%	13
9%-аас их	12




2. Та 2025 онд үнийн өсөлтийн түвшинг хэдэн хувь байна гэж таамаглаж байна вэ?

[More Details](#)

[Insights](#)



3%-аас бага	1
4%	2
5%	7
6%	28
7%	16
8%	11
9%	8
10%-аас их	3



3. Та 2026-2027 онуудад үнийн өсөлтийн түвшинг хэдэн хувь байна гэж таамаглаж байна вэ?

[More Details](#)



[Insights](#)



4. Та 2024 онд эдийн засгийн өсөлт ямар байна гэж бодож байна вэ?

[More Details](#)

[Insights](#)




5. Та 2025 онд эдийн засгийн өсөлт ямар байна гэж бодож байна вэ?

[More Details](#)

[Insights](#)

3 хувиас бага	1
4%	2
5%	9
6%	22
7%	15
8%	18
9%-аас дээш	7




6. Та 2026-2027 онуудад эдийн засгийн өсөлт ямар байна гэж бодож байна вэ?

[More Details](#)

[Insights](#)

0-3%	1
4%	1
5%	16
6%	20
7%	15
8%	12
9%-аас дээш	9



7. Та төсвийн алдагдлыг ямар түвшинд байх нь оновчтой гэж үзэж байна вэ?

[More Details](#)

-2%	17
-1%	10
0%	20
+1%	15
+2%	12



Хавсралт 2. Эдийн засгийн төсөөллийн санал асуулгын дүнгийн задаргаа

	3% ба түүнээс бага	4%	5%	6%	7%	8%	9%	10% ба түүнээс дээш
Та 2024 онд үнийн өсөлтийн түвшинг хэдэн хувь байна гэж таамаглаж байна вэ?	*	1	3	24	23	13	12	*
Та 2025 онд үнийн өсөлтийн түвшинг хэдэн хувь байна гэж таамаглаж байна вэ?	1	2	7	28	16	11	8	3
Та 2026-2027 онуудад үнийн өсөлтийн түвшинг хэдэн хувь байна гэж таамаглаж байна вэ?	3	9	16	12	12	14	6	4
Та 2024 онд эдийн засгийн өсөлт ямар байна гэж бодож байна вэ?	2	7	9	20	20	14	4	*
Та 2025 онд эдийн засгийн өсөлт ямар байна гэж бодож байна вэ?	1	2	9	22	15	18	7	*
Та 2026-2027 онуудад эдийн засгийн өсөлт ямар байна гэж бодож байна вэ?	1	1	16	20	15	12	9	*
	-2%	-1%	0%	1%	2%			
Та төсвийн алдагдлыг ямар түвшинд байх нь оновчтой гэж үзэж байна вэ?	17	10	20	15	12			